



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/06

Бор-Өндөр

Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.5, 3 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Нэгжийн ахлагч:

Ц.Жаргалсайхан

Хууль, эрх зүй дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Мөнхгэрэл

Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны
асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Б.Цогзолмаа

Холбоо 2 дугаар багийн Зохион байгуулагч

2. Нэгжийн ахлагч Ц.Жаргалсайханд үндсэн цалингийн 20 хувь, Ц.Мөнхгэрэл, Б.Цогзолмаа нарт үндсэн цалингийн 10 хувиар тооцож, нэмэгдэл хөлсийг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн сар бүр бодож олгосугай.

3.Засаг даргын Тамгын газрын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” болон холбогдох хууль, тогтоол, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллахыг дотоод хяналтын нэгжид үүрэг болгосугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ